

БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН 2019
ОНЫ III УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	2
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон нэрсийн жагсаалт	3
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	4
Хууль, тогтоомж, журмын хэрэгжилт	5
Аудитын тухай хуулийн хэрэгжилт.....	5
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	5
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт.....	5
Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журмын хэрэгжилт	5
Статистик үзүүлэлтүүд	6
Харилцагчид, зээлдэгчид.....	6
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	6
Тархалт	8
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	9
Мөнгөн хөрөнгө.....	9
Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	10
Факторингийн тооцооны авлага.....	10
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө	10
Бусад хөрөнгө	11
Зээл.....	11
Эргэлтийн бус хөрөнгө	13
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	13
Санхүүгийн эх үүсвэр	13
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	14
Бусад эх үүсвэр	14
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	15
Төслийн зээлийн санхүүжилт	15
Бусад өр төлбөр	15
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	16
Бусад өмч, сангууд	16
Хуримтлагдсан ашиг/алдагдал	17
Хоёрдогч өглөг.....	17
Ашигт ажиллагаа	18
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	19
Дүгнэлт	21

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Санхүүгийн тайлангийн ерөнхий үзүүлэлтүүд.....	4
Хүснэгт 2 Харилцагчдын мэдээлэл.....	6
Хүснэгт 3 ББСБ-ын мэдээлэл	7
Хүснэгт 4 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа, үйлчилгээ	7
Хүснэгт 5 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	8
Хүснэгт 6 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	8
Хүснэгт 7 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	9
Хүснэгт 8 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	9
Хүснэгт 9 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	9
Хүснэгт 10 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	10
Хүснэгт 11 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	10
Хүснэгт 12 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	10

Хүснэгт 13 Бусад хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	11
Хүснэгт 14 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	11
Хүснэгт 15 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	13
Хүснэгт 16 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	13
Хүснэгт 17 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/	14
Хүснэгт 18 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/	14
Хүснэгт 19 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/	14
Хүснэгт 20 ББСБ-аас гарсан өрийн бичиг /мянган төгрөгөөр/	15
Хүснэгт 21 Төслийн зээл санхүүжилт /мянган төгрөгөөр/	15
Хүснэгт 22 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/	15
Хүснэгт 23 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/	16
Хүснэгт 24 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	16
Хүснэгт 25 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	16
Хүснэгт 26 Хуримтлагдсан ашиг/алдагдал	17
Хүснэгт 27 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/	18
Хүснэгт 28 Орлого, үр дүнгийн тайлан /тэрбум төгрөгөөр/	19
Хүснэгт 29 ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо	19
Хүснэгт 30 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/	20

Зургийн жагсаалт

Зураг 1 Зээлийн багцын чанар	12
Зураг 2 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/	12
Зураг 3 Итгэлцлийн өглөг /тэрбум төгрөгөөр/	13
Зураг 4 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	18

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2019 оны III улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 539 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 ББСБ буюу 0.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 74 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 28 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

2019 оны III улирлын байдлаар 9 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 9 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 10 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 8 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээний давлагаанд нэгдсэн ББСБ-уудын тоо 2019 оны III улирлын байдлаар 8 байна.

Хүснэгт 1 Санхүүгийн тайлангийн ерөнхий үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2018-III	2019-III	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	1,202.00	1,628.50	35.5%
<i>Банкны салбартай харьцуулахад хувиар</i>	3.9%	4.7%	0.8%
Нийт өөрийн хөрөнгө	932.0	1,202.50	29.0%
<i>Банкны салбартай харьцуулахад хувиар</i>	30.1%	38.8%	8.7%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	725.6	909.2	25.3%
<i>Банкны салбартай харьцуулахад хувиар</i>	90.5%	107.2%	16.7%
Нийт зээл	811.6	1,169.30	44.1%
<i>Банкны салбартай харьцуулахад хувиар</i>	5.0%	6.5%	1.5%
Нийт орлого	183.9	250.6	36.3%
Нийт зарлага	110.4	150.4	36.2%
Цэвэр ашиг	73.5	100.2	36.3%

ББСБ-уудын нийт хөрөнгийн хэмжээ банкны салбарын 4.7% байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр өссөн байна. 539 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ арилжааны 13 банкны хувь нийлүүлсэн хөрөнгөөс 1.1 дахин их байна.

2019 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.6 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 35.5 хувиар буюу 426.5 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 83.9 хувийг зээлийн үлдэгдэл, пассивын өсөлтийн 43.1 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлогын хэмжээ 36.3 хувиар буюу 66.7 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 36.2 хувиар буюу 40.0 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 36.3 хувиар буюу 26.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 539 ББСБ 9 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 801 үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 494 ББСБ буюу 91.7% нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба эдгээрийн 348 ББСБ буюу 70.4% нь дагнан эрхэлж байгаа бол 155 ББСБ буюу 28.8% нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 45 ББСБ буюу 29.0% нь дагнан эрхэлж байна.

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2018 III	2019 III	тоо	хувь
Нийт ББСБ-ын тоо		540	539	-1	-0.2%
1	Зээл	491	494	3	0.6%
<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>		358	348	-10	-2.8%
2	Факторинг	21	28	7	33.3%
3	Төлбөрийн баталгаа гаргах	18	19	1	5.6%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	3	3	-	-
5	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	23	29	6	26.1%
6	Гадаад валютын арилжаа	153	155	2	1.3%
<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>		46	45	-1	-2.2%
7	Итгэлцэл	29	31	2	6.9%
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	9	10	1	11.1%
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	31	32	1	3.2%

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурсан нь ББСБ-ууд үйл ажиллагааны төрлөө нэмж байгааг харуулж байна. Харин нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл факторингийн үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ өмнөх оны мөн үеэс 26.1 хувиар өссөн байна.

2019 оны III улирлын тайлан мэдээний ирц 96.5% байна.

Тайлан мэдээг ирүүлбэл зохих 539 ББСБ-аас 520 ББСБ улирлын тайлан мэдээг зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 19 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Хууль, тогтоомж, журмын хэрэгжилт

“Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх тухай” Хорооны 2017 оны 27 дугаар тогтоолын хэрэгжилт 2019 оны III улирлын байдлаар 88.4%-тай байна.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын төслийг шинэчлэн боловсруулан, 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, тухайн өдрийн 210 дугаар тогтоолоор батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4437 дугаараар бүртгүүлж, үүний дагуу ББСБ-уудын санхүүгийн тайлангийн мастер файл болон метадатаг шинэчлэн 2019 оны III улирлаас эхлэн шинэчилсэн загвараар тайлан, мэдээг хүлээн авч байна.

Аудитын тухай хуулийн хэрэгжилт

2019 оны III улирлын байдлаар Аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 539 ББСБ-ын 74.8% буюу 403 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 367 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд Монголбанкны зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан зээлдэгчийн талаарх мэдээлэл, лавлагааг зээлийн үйл ажиллагаандаа авч ашиглах үүргийг тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 494 ББСБ-ын 91.3% буюу 451 ББСБ хэрэгжүүлж ажилласан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 182 ББСБ, 7,400 удаагийн тохиолдлоор, 522.8 тэрбум төгрөгийг, 7.2-г “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 3 ББСБ, 5 удаагийн тохиолдлоор, 3.2 тэрбум төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журмын хэрэгжилт

2019 оны III улирлын байдлаар нийт 439 ББСБ 895.1 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн нь 83.1 хувийн биелэлттэй байна.

Статистик үзүүлэлтүүд

2019 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 7,672 хувь нийлүүлэгчдийн 539 ББСБ, 240 салбар нэгж, 7 төлөөлөгчийн газар, 3003 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт 1,575,389 харилцагч, 383,670 зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Хүснэгт 2 Харилцагчдын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	1,575,389	197,437	1,318,493	59,459	1,560,528	14,861	533,285	1,042,104	29,192
Үүнээс: Эмэгтэй	1,226,449	108,512	1,080,288	37,649	1,218,179	8,270	307,238	919,211	16,540
Эрэгтэй	345,453	85,849	238,013	21,591	338,902	6,551	225,860	119,593	12,525
Хуулийн этгээд	3,487	3,076	192	219	3,447	40	187	3,300	127
Итгэмжлэгчдийн тоо	232	228	4	-	232	0	0	232	86
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	167	157	10	-	108	59	1	166	0
Зээлдэгчдийн тоо	383,670	143,762	239,908	-	369,918	13,752	181,235	202,435	26,582
Хэвийн	320,600	129,623	190,977	-	309,167	11,433	141,463	179,137	23,823
Хугацаа хэтэрсэн	37,619	7,280	30,339	-	36,044	1,575	25,291	12,328	832
Чанаргүй:	25,451	6,859	18,592	-	24,707	744	14,481	10,970	1,927
-Хэвийн бус	12,237	2,306	9,931	-	11,890	347	8,120	4,117	419
-Эргэлзээтэй	7,730	1,617	6,113	-	7,591	139	4,759	2,971	396
- Муу	5,484	2,936	2,548	-	5,226	258	1,602	3,882	1,112
Зээлдэгчдийн насжилт	381,375	141,525	239,850	-	367,651	13,724	181,182	200,193	26,460
18-35 насны	208,957	57,641	151,316	-	204,038	4,919	116,950	92,007	10,967
36-45 насны	102,331	47,703	54,628	-	97,601	4,730	40,229	62,102	8,083
46-55 насны	51,185	25,159	26,026	-	48,053	3,132	18,277	32,908	4,805
55-аас дээш	18,902	11,022	7,880	-	17,959	943	5,726	13,176	2,605
Зээлдэгчдийн боловсрол	381,375	141,525	239,850	-	367,651	13,724	181,182	200,193	26,460
-Дээд	225,887	74,372	151,515	-	219,857	6,030	104,817	121,070	9,751
-Тусгай дунд	27,641	15,819	11,822	-	24,677	2,964	8,843	18,798	2,489
-Бүрэн дунд	112,110	41,992	70,118	-	109,265	2,845	61,733	50,377	13,109
-Дунд	13,659	7,282	6,377	-	12,260	1,399	5,787	7,872	1,057
-Бага	2,078	2,060	18	-	1,592	486	2	2,076	54

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өсөж 1,575,389, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 76.3 хувиар өсөж 383,670-д хүрлээ.

Нийт ББСБ-уудын 370 нь буюу 68.6% нь програм хангамжтай байгаа ба програмтай ББСБ-уудын 69.7% буюу нь 258 нь нэр бүхий 2 компанийн програмыг ашиглаж байна.

Нийт харилцагчдын 83.7% буюу 1,318,493 нь, зээлдэгчдийн 62.5% буюу 239,908 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай онлайн зээлийн

үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 12.5% буюу 197,437, зээлдэгчдийн 37.5% буюу 143,763 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валют арилжааны үйлчилгээ дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 59,459 буюу нийт харилцагчдын 3.8 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн 6,631 буюу 86.4% нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,041 буюу 13.6% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 1,061 буюу 13.8% нь

гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 171 буюу 2.2% нь хөдөө орон нутгийн хувьцаа эзэмшигчид байна.

Мөн уламжлалт зээлийн үйлчилгээний болон финтек зээлийн үйлчилгээний ББСБ-уудын хувьцаа эзэмшигчдийн хүйсийг харвал технологид

суурилсан үйлчилгээний ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн 53.8% нь эрэгтэйчүүд байгаа бол уламжлалт зээлийн үйлчилгээний ББСБ-уудын хувьцаа эзэмшигчдийн 65.1% нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 3 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Хувь нийлүүлэгчдийн тоо	7,672	1,678	5,926	68	7,501	171	6,631	1,041	1,063
Үүнээс: Эмэгтэй	3,840	1,093	2,720	27	3,770	70	3,430	410	875
Эрэгтэй	3,732	507	3,186	39	3,637	95	3,185	547	166
Хуулийн этгээд	100	78	20	2	94	6	16	84	22
Нийт ажилтнуудын тоо	3,003	2,596	272	135	2,815	188	202	2,801	339
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	1,743	1,493	164	86	1,615	128	122	1,621	176

Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудаас 2 ББСБ цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ давхар эрхэлж байна. Хөдөө орон нутгийн 74 ББСБ 5 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд 81 үйл ажиллагаа эрхэлж байна. Одоогоор үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ байхгүй байна.

Хүснэгт 4 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа, үйлчилгээ

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
ТЗ-тэй ББСБ-ын тоо	539	486	8	45	465	74	4	535	28	511
ТЗ-тэй үйлчилгээний тоо	801	724	30	47	720	81	21	780	55	746
ТЗ-тэй үйл ажиллагааны тоо	9	9	9	2	9	5	9	9	8	9
1 Зээл	494	486	8	-	422	72	4	490	28	466
2 Факторингийн үйлчилгээ	28	24	4	-	28	-	2	26	2	26
3 Төлбөрийн баталгаа гаргах	19	18	1	-	19	-	1	18	5	14
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	3	1	2	-	3	-	1	2	-	3
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	29	24	3	2	29	-	2	27	1	28
6 Гадаад валютын арилжаа	155	106	4	45	149	6	3	152	9	146
7 Итгэлцлийн үйлчилгээ	31	27	4	-	30	1	3	28	3	28
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	10	8	2	-	9	1	2	8	2	8
9 Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	32	30	2	-	31	1	3	29	5	27
10 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	-	-	-	-	-	-	-	-	-	-

Тархалт

Хүснэгт 5 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн 74	Салбар 74	Нийт 148	Хувь 100.0%
Төв	11	2	13	8.8%
Дархан-Уул	7	10	17	11.5%
Орхон	7	11	18	12.2%
Өвөрхангай	6	5	11	7.4%
Сэлэнгэ	6	4	10	6.8%
Дорнод	5	6	11	7.4%
Баянхонгор	4	4	8	5.4%
Сүхбаатар	4	2	6	4.1%
Баян-Өлгий	3	1	4	2.7%
Хөвсгөл	3	5	8	5.4%
Хэнтий	3	2	5	3.4%
Булган	2	-	2	1.4%
Говьсүмбэр	2	1	3	2.0%
Дорноговь	2	4	6	4.1%
Завхан	2	1	3	2.0%
Увс	2	3	5	3.4%
Архангай	1	1	2	1.4%
Говь-Алтай	1	-	1	0.7%
Дундговь	1	1	2	1.4%
Өмнөговь	1	8	9	6.1%
Ховд	1	3	4	2.7%

Хүснэгт 6 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн 465	Салбар 166	Нийт 631	Хувь 100.0%
Сүхбаатар	162	23	185	29.3%
Чингэлтэй	145	25	170	26.9%
Баянгол	68	28	96	15.2%
Баянзүрх	52	44	96	15.2%
Хан-Уул	30	18	48	7.6%
Сонгинохайрхан	7	22	29	4.6%
Багануур	1	4	5	0.8%
Налайх	-	2	2	0.3%
Багахангай	-	-	-	-

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 86.3% буюу 465 ББСБ, салбаруудын 69.2% буюу 166 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 13.7% буюу 74 ББСБ, салбаруудын 30.8% буюу 74 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт

2019 оны III улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 1.6 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.5 хувиар буюу 426.5 тэрбум төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 83.9 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхэнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 7 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2018-III дүн	2018-IV дүн	2019-III дүн	Эзлэх хувь	Өөрчлөлт			
					өмнөх оны мөн үе		оны эхэн	
					дүн	хувь	дүн	хувь
Эргэлтийн хөрөнгө	1,155,366.7	1,234,705.7	1,571,920.0	96.5%	416,553.3	36.1%	337,214.3	27.3%
Мөнгөн хөрөнгө	298,877.0	315,113.9	342,913.2	21.1%	44,036.2	14.7%	27,799.3	8.8%
Богино хугацаат хөрөнгө оруулалт (цэврээр)	1,479.0	1,837.5	2,373.4	0.1%	894.4	60.5%	535.9	29.2%
Зээл (цэврээр)	748,230.5	804,745.6	1,090,929.1	67.0%	342,698.7	45.8%	286,183.5	35.6%
Нийт зээл	811,600.7	869,222.4	1,169,270.1	71.8%	357,669.5	44.1%	300,047.7	34.5%
(Зээлийн эрсдэлийн сан)	63,370.2	64,476.9	78,341.0	4.8%	14,970.8	23.6%	13,864.1	21.5%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	232.7	7,292.9	4,187.5	0.3%	3,954.8	18.0	(3,105.4)	-42.6%
Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	9,614.3	10,223.0	9,277.4	0.6%	(336.8)	-3.5%	(945.6)	-9.2%
Бусад хөрөнгө	96,933.2	95,492.8	122,239.3	7.5%	25,306.1	26.1%	26,746.5	28.0%
Эргэлтийн бус хөрөнгө	46,608.8	50,191.7	56,600.9	3.5%	9,992.2	21.4%	6,409.2	12.8%
Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр)	56,951.5	61,462.4	69,577.4	4.3%	12,625.9	22.2%	8,114.9	13.2%
(Хуримтлагдсан элэгдэл)	(10,342.7)	(11,270.7)	(12,976.5)	-0.8%	(2,633.7)	25.5%	(1,705.7)	15.1%
Нийт хөрөнгийн дүн	1,201,975.5	1,284,897.4	1,628,520.9	100%	426,545.5	35.5%	343,623.5	26.7%

Активын үзүүлэлтүүдийн өөрчлөлтүүдийг харахад өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт үзүүлсэн нь богино хугацаат хөрөнгө оруулалт байна. Өмнөх оны мөн үеэс 60.5% буюу 894.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 8 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	849.5	52	52.2%	9.6%	5.4	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	261.1	81	16.0%	15.0%	2.7	1	3.8	1	-	-
1.9-2.5 тэрбум	129.3	60	7.9%	11.1%	-	-	-	-	-	-
1.4-1.9 тэрбум	299.5	187	18.4%	34.7%	-	-	1.4	1	1.6	1
0.6-1.4 тэрбум	69.3	64	4.3%	11.9%	4.7	6	7.5	8	3.9	4
0.6 тэрбум хүртэлх	19.8	95	1.2%	17.6%	2.0	5	11.0	51	6.6	40
НИЙТ	1,628.5	539	100%	100%	14.8	13	23.6	61	12.0	45

2.5 тэрбум ба түүнээс дээш активтай 133 ББСБ-ын нийт хөрөнгийн хэмжээ салбарын нийт активын 1.1 их наяд төгрөг буюу 68.2 хувийг бүрдүүлж байна.

Харин 2.5 тэрбум хүртэлх активтай 406 ББСБ-ын 517.9 тэрбум төгрөгийн хөрөнгө салбарын нийт активын 517.9 тэрбум төгрөг буюу 31.8 хувийг бүрдүүлж байна.

Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн 47.5% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 32.0% нь банк, санхүүгийн байгууллагын харилцах дансанд 20.5% нь банк, санхүүгийн байгууллагын хадгаламжийн дансанд байршиж байна.

Хүснэгт 9 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
МӨНГӨН ХӨРӨНГӨ	342.9	310.6	20.7	11.6	335.2	7.7	11.6	331.3	22.3
Бэлэн мөнгө	162.9	150.6	1.3	11.0	157.4	5.5	0.0	162.8	3.0
Харилцах	109.8	98.4	10.7	0.7	108.1	1.8	6.3	103.5	13.8
Хадгаламж	70.2	61.5	8.7	-	69.7	0.5	5.3	65.0	5.5

Уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл 48.5% нь бэлэн мөнгө хэлбэрээр байгаа бол финтек ББСБ-уудын мөнгөн

хөрөнгийн 6.1% нь бэлэн мөнгө хэлбэрээр, валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-ууд үйл ажиллагааны онцлогоос хамаарч мөнгөн хөрөнгийн 94.3% нь бэлэн мөнгө хэлбэрээр байршиж байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалт

Өмнөх оны мөн үед 19 ББСБ 1.5 тэрбум төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт авсан байсан. 2019 оны III улирлын байдлаар 2 ББСБ-ын 774.1 сая төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт нэмэгдсэн бол 5 ББСБ-ын 937.9 сая төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт хасагдсан, 3 ББСБ шинээр 1,058.0 сая төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт нэмж татсан байна. 2019 оны III улирлын байдлаар 17 ББСБ-ын 2.4 тэрбум төгрөгийн богино хугацаат хөрөнгө оруулалт байна.

Богино хугацаат хөрөнгө оруулалтын 96.0% буюу 2.3 тэрбум төгрөгийг арилжааны үнэт цаас бүрдүүлж байгаа бол 4.0% буюу 93.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын үнэт цаас бүрдүүлж байна. Төрлөөр авч үзвэл 99.8% буюу 2.4 тэрбум төгрөг нь хувьцаа байгаа бол 0.2% буюу 5.0 сая төгрөг нь бусад үнэт цаасны хөрөнгө оруулалт байна.

Хүснэгт 10 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
БХХО (ЦЭВРЭЭР)	2,373.4	1,760.2	612.2	1.0	1,717.0	656.4	612.2	1,761.2	-
Хувьцаа	2,368.4	1,755.2	612.2	1.0	1,712.0	656.4	612.2	1,756.2	-
Бусад	5.0	5.0	-	-	5.0	-	-	5.0	-
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	93.9	44.9	49.0	-	92.9	1.0	49.0	44.9	-
Арилжааны үнэт цаас	2,279.5	1,715.4	563.2	1.0	1,624.2	655.4	563.2	1,716.4	-

Факторингийн тооцооны авлага

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад факторингийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл 33.3 хувиар нэмэгдсэн. Гэвч 2019 оны III улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 28 ББСБ-аас Улаанбаатар хотод байршилтай, уламжлалт санхүүгийн үйл ажиллагаа явуулж байгаа 3 ББСБ 171.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй факторингийн үлдэгдэлд 36.1 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж 4,187.5 сая төгрөгийн цэвэр үлдэгдэлтэй гарчээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 18 дахин нэмэгдсэн дүн хэдий ч факторингийн тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудын 10.7% нь үйл ажиллагаа явуулж байгаа нь хангалтгүй байна.

Хүснэгт 11 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/

Нийт факторингийн тооцооны авлага	Нийт дүн	Эзлэх хувь
	4,223.6	100.0%
Хэвийн	4,052.6	95.9%
Хугацаа хэтэрсэн	105.0	2.5%
Чанаргүй	66.1	1.6%
Хэвийн бус	16.6	0.4%
Эргэлзээтэй	45.4	1.1%
Муу	4.0	0.1%
(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	(36.1)	-

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 336.8 сая төгрөг буюу 3.5 хувиар буурсан дүнтэй гарчээ.

Хүснэгт 12 ӨБҮХХ болон ӨБХ-ийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВ А	УБ	ХОН	ХК	ХХ К	ГХО
ӨБҮХХ БОЛОН ӨБХ (ЦЭВРЭЭР)	9.3	9.1	0.1	-	9.1	0.1	0.1	9.1	1.9
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	10.9	10.0	0.8	-	10.7	0.1	0.8	10.0	2.2
(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдэлийн сан)	3.2	2.5	0.7	-	3.2	-	0.7	2.5	1.2
Өмчлөх бусад хөрөнгө	1.6	1.6	0.0	-	1.6	0.0	0.0	1.6	0.9

Бусад хөрөнгө

Бусад хөрөнгийн 51.9% буюу 63.4 тэрбум төгрөг нь хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, 26.2% буюу 32.0 тэрбум төгрөг нь цэвэр авлага, 21.9% буюу 26.7 тэрбум төгрөг нь бусад актив байна.

Хүснэгт 13 Бусад хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
БУСАД ХӨРӨНГӨ	122.2	108.1	13.9	0.2	118.6	3.7	10.0	112.3	23.7
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	63.5	58.3	5.1	-	62.4	1.1	4.1	59.4	13.8
-Үнэт цаасны	0.1	0.1	-	-	0.1	-	-	0.1	-
-Зээлийн	60.7	56.8	3.8	-	59.6	1.1	3.2	57.5	13.7
-Факторингийн	0.1	0.1	-	-	0.1	-	-	0.1	-
-Бусад	2.6	1.3	1.3	-	2.6	0.0	0.9	1.7	0.1
Авлага /цэврээр/	32.0	27.8	4.2	0.1	30.4	1.7	2.4	29.6	2.2
<i>Нийт авлага</i>	<i>33.5</i>	<i>28.5</i>	<i>4.9</i>	<i>0.1</i>	<i>31.8</i>	<i>1.7</i>	<i>2.5</i>	<i>31.0</i>	<i>2.6</i>
Хэвийн	31.5	27.2	4.2	0.1	29.8	1.7	2.4	29.0	2.1
Хугацаа хэтэрсэн	0.5	0.5	-	0.0	0.5	0.0	-	0.5	0.1
Чанаргүй:	1.5	0.8	0.7	-	1.5	0.0	0.1	1.5	0.4
-Хэвийн бус	0.1	0.1	-	-	0.1	0.0	-	0.1	0.0
-Эргэлзээтэй	0.1	0.1	-	-	0.1	0.0	-	0.1	0.1
-Муу	1.4	0.7	0.7	-	1.4	0.0	0.1	1.3	0.3
<i>Нийт авлага (валютын)</i>	<i>4.4</i>	<i>4.4</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>4.4</i>	<i>-</i>	<i>-</i>	<i>4.4</i>	<i>-</i>
<i>Нийт авлага (төгрөгийн)</i>	<i>29.1</i>	<i>24.1</i>	<i>4.9</i>	<i>0.1</i>	<i>27.4</i>	<i>1.7</i>	<i>2.5</i>	<i>26.6</i>	<i>2.6</i>
<i>(Авлагын эрсдэлийн сан)</i>	<i>1.4</i>	<i>0.7</i>	<i>0.7</i>	<i>-</i>	<i>1.4</i>	<i>0.0</i>	<i>0.1</i>	<i>1.4</i>	<i>0.4</i>
Бусад актив	26.8	22.0	4.6	0.1	25.9	0.9	3.4	23.3	7.7

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 44.1% буюу 357.7 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 34.5% буюу 300.0 тэрбум төгрөгөөр өсөж 2019 оны III улирлын байдлаар 1.2 их наяд төгрөгийн зээлд 78.3 сая төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 1.1 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Оны эхэнд 468 ББСБ 866.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 437 ББСБ 1.3 их наяд төгрөгийн зээлийг 3.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 442 ББСБ-ын 1.0 их наяд төгрөгийн зээл төлөгдөж, 476 ББСБ 1.2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Хүснэгт 14 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Нийт	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Догоод
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	1,090.9	932.4	158.5	1,065.8	25.1	121.2	969.7	168.8	922.1
Нийт зээл	1,169.3	1,006.4	162.9	1,139.0	30.3	124.8	1,044.5	180.4	988.9
Хэвийн	1,015.8	866.8	149.0	993.1	22.7	113.5	902.3	158.0	857.8
Хугацаа хэтэрсэн	48.8	41.5	7.3	47.0	1.8	5.7	43.1	6.9	41.9
Чанаргүй:	104.7	98.1	6.6	98.9	5.9	5.6	99.1	15.5	89.2
-Хэвийн бус	24.0	21.0	3.1	23.6	0.5	2.7	21.4	3.3	20.7
-Эргэлзээтэй	24.9	22.4	2.5	24.1	0.8	2.2	22.7	4.3	20.6
-Муу	55.8	54.8	1.0	51.2	4.6	0.8	55.0	7.9	47.9
(Зээлийн эрсдэлийн сан)	78.3	74.0	4.3	-	73.2	5.2	3.6	74.7	3.6
Нийт зээл (төгрөгийн)	1,135.2	984.0	151.1	1,105.0	30.2	113.2	1,022.0	165.5	969.7
Нийт зээл (валютын)	34.1	22.4	11.7	34.0	0.1	11.6	22.5	14.9	19.2
Зээлдэгчдийн тоо	383,670	143,762	239,908	369,918	13,752	181,235	202,435	26,582	357,088
Олгосон зээл	1,304.7	825.2	479.5	1,281.4	23.4	386.7	918.0	141.6	1,163.1
Олгосон ЗЖДХ	3.1%	3.0%	3.5%	3.1%	3.6%	3.7%	2.9%	2.8%	3.2%
-Хувь хүн	1,169.2	705.0	464.2	1,148.4	20.9	373.3	796.0	123.1	1,046.1
Олгосон ЗЖДХ	3.2%	3.1%	3.5%	3.2%	3.7%	3.7%	3.0%	2.9%	3.3%
-Хуулийн этгээд	135.5	120.2	15.3	133.0	2.5	13.5	122.0	18.5	117.0
Олгосон ЗЖДХ	2.4%	2.4%	2.3%	2.4%	2.3%	2.3%	2.4%	2.5%	2.4%
Төлөгдсөн зээл	1,001.6	607.0	394.6	982.7	19.0	325.7	676.0	108.0	893.6
-Хувь хүн	890.3	503.6	386.7	873.6	6.8	318.8	571.6	96.7	793.6
-Хуулийн этгээд	111.3	103.4	7.9	109.1	2.2	6.9	104.4	11.3	100.0

Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 0.2 болон 1.6 пунктээр тус тус буурсан бол хэвийн зээлийн хэмжээ 1.8 пунктээр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 153.7 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 51.0%-д буюу 78.3 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.


Зураг 1 Зээлийн багцын чанар



Нийт олгосон зээлийн 66.7% буюу 869.6 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлд, 12.4% буюу 161.3 тэрбум төгрөг нь худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 68.1% буюу 681.8 тэрбум төгрөг нь хэрэглээний зээлээс, 14.4% буюу 144.6 тэрбум төгрөг нь худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Олгосон зээлийн 89.6% буюу 1.2 их наяд төгрөгийн зээлийг хувь хүнд, 10.4% буюу 135.5 тэрбум төгрөгийг зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол төлөгдсөн зээлийн 88.9% буюу 890.3 тэрбум төгрөг нь хувь хүнээс, 11.1% нь буюу 111.3 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

Зураг 2 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /тэрбум төгрөгөөр/



Эргэлтийн бус хөрөнгө

ББСБ-ууд 2019 оны III улирлын байдлаар 69.6 тэрбум төгрөгийн үндсэн, биет ба биет бус хөрөнгөд 13.0 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

Хүснэгт 15 Эргэлтийн бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

ҮНДСЭН (БИЕТ) БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	69.6	65.4	3.8	0.4	68.0	1.6	2.9	66.7	6.5
Барилга байгууламж	23.1	23.0	0.019	0.003	22.6	0.4	0.018	23.05	0.5
Техник хэрэгсэл	26.3	25.1	1.1	0.1	25.4	0.9	0.8	25.53	2.5
Тавилга эд хогшил	8.8	8.0	0.6	0.2	8.6	0.2	0.4	8.44	0.9
Дуусаагүй барилга	5.6	5.3	0.3	-	5.6	0.001	0.2	5.46	1.8
Биет бус хөрөнгө	5.8	3.9	1.8	0.002	5.7	0.1	1.5	4.24	0.7
(Хуримтлагдсан элэгдэл)	13.0	12.4	0.5	0.1	12.5	0.5	0.3	12.7	1.7
Барилга байгууламжийн	1.9	1.9	0.001	0.001	1.8	0.1	0.001	1.87	0.1
Техник хэрэгслийн	8.1	7.7	0.4	0.1	7.8	0.3	0.3	7.88	1.3
Тавилга эд хогшлын	3.0	2.8	0.1	0.1	2.9	0.1	0.1	2.90	0.3

Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


Салбарын нийт пассив өмнөх оны мөн үеэс 35.5 хувиар өссөн ба энэхүү өсөлтийн 43.1 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Пассивын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үе болон оны эхэнтэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 16 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2018-III дүн	2018-IV дүн	2019-III дүн	Эзлэх хувь	Өөрчлөлт			
					өмнөх оны мөн үе		оны эхэн	
					дүн	хувь	дүн	хувь
Өр төлбөр	270,020.3	307,453.8	425,979.8	26.2%	155,959.5	57.8%	118,526.0	38.6%
Санхүүгийн эх үүсвэр	48,750.8	57,607.1	97,023.2	6.0%	48,272.4	99.0%	39,416.1	68.4%
Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	135,550.2	151,009.6	188,272.5	11.6%	52,722.3	38.9%	37,262.9	24.7%
Бусад эх үүсвэр	9,405.6	15,668.3	15,052.7	0.9%	5,647.1	60.0%	(615.6)	-3.9%
ББСБ-аас гаргасан өрийн бичиг	21,079.8	23,477.8	40,810.7	2.5%	19,730.9	93.6%	17,332.9	73.8%
Төслийн зээлийн санхүүжилт	16,893.4	17,848.8	17,349.5	1.1%	456.1	2.7%	(499.3)	-2.8%
Бусад өр төлбөр	38,340.5	41,842.2	67,464.4	4.1%	29,123.9	76.0%	25,622.2	61.2%
Эздийн өмч	931,955.2	977,443.6	1,202,541.2	73.8%	270,586.0	29.0%	225,097.6	23.0%
Хувьцаат капитал	725,563.5	740,759.0	909,238.3	55.8%	183,674.8	25.3%	168,479.3	22.7%
Бусад өмч	9,202.9	10,598.7	27,849.5	1.7%	18,646.6	202.6%	17,250.8	162.8%
Сангууд	587.0	532.7	774.7	0.0%	187.7	32.0%	242.0	45.4%
Хуримтлагдсан ашиг/алдагдал	195,635.3	224,586.5	263,842.1	16.2%	68,206.8	34.9%	39,255.6	17.5%
Хоёрдогч өглөг	966.6	966.6	836.6	0.1%	(130.0)	-13.5%	(130.0)	-13.5%
Нийт хөрөнгийн дүн	1,201,975.5	1,284,897.4	1,628,520.9	100.0%	426,545.4	35.5%	343,623.5	26.7%

Санхүүгийн эх үүсвэр

Зураг 3 Итгэлцлийн өглөг /тэрбум төгрөгөөр/



2019 оны III улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний дүн өмнөх оны мөн үеэс 99.0% буюу 48.3 тэрбум төгрөгөөр өсөж, итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 31 ББСБ-аас 24 ББСБ 1,778 итгэмжлэгчээс 97.0 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна.

Улаанбаатар хотын 23 ББСБ 1,775 итгэмжлэгчээс 95.9 тэрбум төгрөг, хөдөө орон нутгийн 1 ББСБ 3 итгэмжлэгчээс 1.2 тэрбум төгрөг мөн гадаадын хөрөнгө оруулалттай 3 ББСБ 207 итгэмжлэгчээс 27.2 тэрбум төгрөгийн итгэлцэл татан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 17 Итгэлцлийн үйлчилгээ /тэрбум төгрөгөөр/

Итгэлцлийн үйлчилгээний өглөг	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	97.0	59.5	37.5	95.9	1.2	35.5	61.5	27.2
-Төгрөгөөр	75.7	54.0	21.7	74.5	1.2	19.7	56.0	19.7
-Валютаар	21.3	5.5	15.8	21.3	-	15.8	5.5	7.5
Итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын тоо	31	27	4	30	1	3	28	3
-Үүнээс итгэлцлийн үйлчилгээний өглөгтэй ББСБ-уудын тоо	24	20	4	23	1	3	21	3
Нийт итгэмжлэгчдийн тоо	1,778	1,634	144	1,775	3	140	1,638	207

Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг

Өмнөх оны мөн үеийн байдлаар 75 ББСБ дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагын 135.6 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байсан бол энэ онд өмнөх оны мөн үеэс 38.9% буюу 52.7 тэрбум төгрөгөөр өсөж 91 ББСБ дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагын 188.3 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 18 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
	188.3		158.0	30.3	187.6	0.6	28.3	160.0	51.1	137.1
Хугацаагаар:										
Богино хугацаат зээл /1 жил хүртэлх/	95.5	50.7%	78.8	16.7	95.3	0.2	14.7	80.8	36.2	59.4
Урт хугацаат зээл /1 жилээс дээш/	92.7	49.3%	79.2	13.5	92.3	0.5	13.5	79.2	15.0	77.8
Валютын төрлөөр:										
Төгрөгөөр	53.2	28.2%	51.1	2.1	53.2	-	0.1	53.1	27.1	26.1
Валютаар	135.1	71.8%	106.9	28.2	134.5	0.6	28.2	106.9	24.1	111.1
Зээл авсан байгууллагаар:										
Дотоодын банк, санхүүгийн байгууллагаас	138.5	73.6%	108.2	30.3	137.9	0.6	28.3	110.2	24.1	114.4
Зээл /төгрөгөөр/	135.1	71.8%	106.9	28.2	134.5	0.6	28.2	106.9	24.1	111.1
Зээл /валютаар/	3.4	1.8%	1.3	2.1	3.4	-	0.1	3.3	-	3.4
Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас	49.8	26.4%	49.8	-	49.8	-	-	49.8	27.1	22.7

Бусад эх үүсвэр

Хүснэгт 19 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	2,858.8	1,930.3	925.6	3.0	2,858.8	-	925.6	1,933.2	733.5	2,125.3
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	4,059.7	-	4,059.7	-	4,059.7	-	-	4,059.7	-	4,059.7
Факторингийн үйлчилгээний өглөг	8,134.2	8,134.2	-	-	8,134.2	-	-	8,134.2	-	8,134.2

Өмнөх оны мөн үед 9 ББСБ 6.1 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй, 1 ББСБ 3.3 тэрбум төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгтэй байсан бол 2019 оны III улиралд 7 ББСБ 2.9 тэрбум төгрөгийн мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөгтэй, 1 ББСБ 4.1 тэрбум төгрөгийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөгтэй, 2 ББСБ 8.1 тэрбум төгрөгийн факторингийн үйлчилгээний өглөгтэй гарсан нь өмнөх оны мөн үеэс 60.5% буюу 5.6 тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудаас бусад эх үүсвэрийн үлдэгдэлтэй ББСБ байхгүй байна.

ББСБ-аас гаргасан өрийн бичиг

Өмнөх оны мөн үед 18 ББСБ 21.1 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргасан байсан бол 2019 оны III улирлын байдлаар 30 ББСБ 40.8 тэрбум төгрөгийн өрийн бичиг гаргажээ.

Хүснэгт 20 ББСБ-аас гарсан өрийн бичиг /мянган төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Уламжлалт	Финтек	УБ	ХОН	ХК	ХХК
	40,810,675.5	30,235,742.4	10,574,933.1	40,698,875.5	111,800.0	6,734,933.1	34,075,742.4
Төгрөгөөр	38,337,653.0	29,262,719.9	9,074,933.1	38,225,853.0	111,800.0	5,234,933.1	33,102,719.9
Валютаар	2,473,022.5	973,022.5	1,500,000.0	2,473,022.5	-	1,500,000.0	973,022.5

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудаас өрийн бичиг гаргасан ББСБ байхгүй байна. Өрийн бичиг гаргасан ББСБ-уудаас 30 ББСБ төгрөгөөр, 3 ББСБ валютаар өрийн бичиг гаргасан.

Төслийн зээлийн санхүүжилт

Өмнөх оны мөн үед 36 ББСБ 16.9 тэрбум төгрөгийн төслийн зээлийн санхүүжилтийн үлдэгдэлтэй байсан бол 2019 оны III улирлын байдлаар 39 ББСБ 17.3 тэрбум төгрөгийн төслийн зээл санхүүжилтийн үлдэгдэлтэй гарчээ.

Финтек болон нээлттэй хувьцаат компаниуд төслийн зээл санхүүжилтийн үлдэгдэлгүй байна.

Хүснэгт 21 Төслийн зээл санхүүжилт /мянган төгрөгөөр/

ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТ	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Уламжлалт	УБ	Нийт дүнд эзлэх хувь	ХОН	Нийт дүнд эзлэх хувь	ГХО
	17,349,489.5		17,349,489.5	16,924,480.2		425,009.3		8,395,450.0
Хугацаагаар								
Богино хугацаат /1 жил хүртэлх/	4,466,827.2	25.7%	4,466,827.2	4,057,387.2	24.0%	409,440.0	96.3%	241,000.0
Урт хугацаат /1 жилээс дээш/	12,882,662.4	74.3%	12,882,662.4	12,867,093.1	76.0%	15,569.3	3.7%	8,154,450.0
Төрлөөр								
Засгийн газрын	1,391,666.7	8.0%	1,391,666.7	1,191,666.7	7.0%	200,000.0	47.1%	-
Гадаадын	9,743,745.4	56.2%	9,743,745.4	9,743,745.4	57.6%	-	0.0%	-
Дотоодын	5,154,363.6	29.7%	5,154,363.6	4,974,923.6	29.4%	179,440.0	42.2%	-
Бусад	1,059,713.9	6.1%	1,059,713.9	1,014,144.6	6.0%	45,569.3	10.7%	8,004,450.0
Валютын төрлөөр								
Төгрөгөөр	14,133,289.5	81.5%	14,133,289.5	13,708,280.2	81.0%	425,009.3	100.0%	5,179,250.0
Валютаар	3,216,200.0	18.5%	3,216,200.0	3,216,200.0	19.0%	-	0.0%	3,216,200.0

Бусад өр төлбөр

Өмнөх оны мөн үед 473 ББСБ 38.3 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байсан бол 2019 оны III улирлын байдлаар 491 ББСБ 67.5 тэрбум төгрөгийн бусад өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 22 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/

БУСАД ӨР ТӨЛБӨР	Дүн	Уламж- лалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Догоод
	67,464.4	41,093.1	26,095.4	276.0	66,450.2	1,014.2	8,599.6	58,864.8	10,619.2	56,845.3
Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	17,126.5	11,284.9	5,841.6	-	17,125.6	0.9	5,635.1	11,491.4	5,946.0	11,180.5
Ангилалаар										
Зээлийн	12,483.9	8,468.8	4,015.1	-	12,483.8	0.1	3,839.4	8,644.4	4,359.4	8,124.5
Үнэт цаасны	578.6	209.0	369.5	-	577.9	0.7	338.7	239.9	-	578.6
Бусад	4,064.0	2,607.1	1,457.0	-	4,063.9	0.1	1,457.0	2,607.1	1,586.6	2,477.4
Валютын төрлөөр										
Төгрөгөөр	15,859.9	10,436.9	5,423.0	-	15,859.0	0.9	5,216.5	10,643.4	5,371.4	10,488.5
Валютаар	1,266.6	848.0	418.6	-	1,266.6	-	418.6	848.0	574.6	692.0
БУСАД ПАССИВ	50,338.0	29,808.3	20,253.8	276.0	49,324.7	1,013.3	2,964.6	47,373.4	4,673.2	45,664.8

Хувь нийлүүлсэн хөрөнгө

2019 оны III улирлын байдлаар 539 ББСБ-ын 909.0 тэрбум төгрөгийн энгийн хувьцаа, 5 ББСБ-ын 728.0 сая төгрөгийн давуу эрхийн хувьцаа, 3 ББСБ-ын 476.5 сая төгрөгийн халаасны хувьцаа бүртгэгдсэн байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 25.3% буюу 183.7 тэрбум төгрөгөөр өсөж 909.2 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт пассивын 55.8 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 23 Хувьцаат капиталын бүтэц /сая төгрөгөөр/

Хувьцаат капитал	Дүн	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
	909,238.3	849,647.4	48,736.0	10,854.9	878,476.4	30,761.9	28,804.8	880,433.4	89,479.8	819,758.5
Энгийн хувьцаа	908,986.7	849,129.7	49,002.1	10,854.9	878,255.4	30,731.3	29,074.5	879,912.2	89,362.4	819,624.3
Давуу эрхтэй хувьцаа	728.0	728.0	-	-	697.4	30.6	-	728.0	121.0	607.0
Халаасны хувьцаа	476.5	210.4	266.1	-	476.5	-	269.7	206.8	3.6	472.9

1.9 тэрбум ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 137 ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 52.7% буюу 478.6 тэрбум төгрөг байна.

Хүснэгт 24 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо	ХНХ	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	179.3	21	19.7%	3.9%	5.6	1	-	-	-	-
2.5-5.0 тэрбум	222.7	79	24.5%	14.7%	2.5	1	-	-	-	-
1.9-2.5 тэрбум	76.7	37	8.4%	6.9%	-	-	2.3	1	-	-
1.4-1.9 тэрбум	364.6	253	40.1%	46.9%	-	-	-	-	1.4	1
0.6-1.4 тэрбум	49.0	51	5.4%	9.5%	2.0	3	6.9	8	3.7	4
0.6 тэрбум хүртэлх	16.9	98	1.9%	18.2%	3.3	8	8.1	52	5.8	40
НИЙТ	909.2	539	100.0%	100.0%	13.4	13	17.4	61	10.9	45

Харин 1.9 тэрбум хүртэлх хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 402 ББСБ-ын 430.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 47.3 хувийг бүрдүүлж байна.

Бусад өмч, сангууд

Бусад өмч өмнөх оны мөн үеэс 3.0 дахин өссөн байна. Энэхүү өсөлт нь нийтэд нээлттэй хувьцаагаа санал болгосон 2 ББСБ-ын нэмж төлөгдсөн капиталын өсөлтөөс 100.0% хамаарч байна.

Хүснэгт 25 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Бусад өмч	27,849.5	5,574.4	22,161.1	114.0	27,484.3	365.2	22,161.1	5,688.4	16,205.3	11,644.3
Нэмж төлөгдсөн капитал	23,623.3	1,441.8	22,103.7	77.7	23,520.0	103.3	22,103.7	1,519.5	16,199.0	7,424.3
Дахин үнэлгээний нэмэгдэл	2,006.9	2,006.9	-	-	1,879.2	127.7	-	2,006.9	6.3	2,000.6
Хандивын капитал	2,219.4	2,125.7	57.3	36.4	2,085.2	134.2	57.3	2,162.1	-	2,219.4
Сангууд	774.7	774.7	-	-	213.3	561.4	-	774.7	3.6	771.1
Нөөцийн сан	550.5	550.5	-	-	139.4	411.1	-	550.5	-	550.5
Нийгмийн хөгжлийн сан	224.2	224.2	-	-	73.9	150.3	-	224.2	3.6	220.6

Хуримтлагдсан ашиг/алдагдал

Хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 34.9% буюу 68.2 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 17.5% буюу 39.3 тэрбум төгрөгөөр өсөж 268.2 тэрбум төгрөгт хүрчээ.

Хүснэгт 26 Хуримтлагдсан ашиг/алдагдал

	АШИГ/АЛДАГДАЛ						
	ХУРИМТЛАГДСАН		-Тухайн үеийн		-Хуримтлагдсан		
2018.III	195,635,269.39		73,497,602.22		122,137,667.16		
2019.III	263,842,106.39		100,162,310.25		163,679,796.09		
	ББСБ тоо	Дүн	ББСБ тоо	Дүн	ББСБ тоо	Дүн	ББСБ тоо
Уламжлалт	539	246,117,393.37	478	86,768,766.48	476	159,348,626.88	425
Финтек	8	16,936,732.80	8	13,399,721.28	8	3,537,011.54	8
ЗГВА	45	787,980.22	45	(6,177.51)	44	794,157.67	45
УБ	465	260,441,951.29	460	97,092,118.93	457	163,349,832.29	422
ХОН	74	3,400,155.10	71	3,070,191.32	71	329,963.80	56
ХК	4	15,035,345.88	4	11,598,433.76	4	3,436,912.12	4
ХХК	535	248,806,760.51	527	88,563,876.49	524	160,242,883.97	474
ГХО	27	20,239,805.34	27	14,703,600.84	27	5,536,204.51	25
Дотоод	512	243,602,301.05	504	85,458,709.41	501	158,143,591.58	453


Хоёрдогч өглөг

Өмнөх оны мөн үед 6 ББСБ 966.6 сая төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байсан бол 1 ББСБ-ын 130.0 сая төгрөгийн хоёрдогч өглөгийн хасагдаж 2019 оны III улирлын байдлаар 5 ББСБ 836.6 сая төгрөгийн хоёрдогч өглөгийн үлдэгдэлтэй байна.

Ашигт ажиллагаа

2019 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 250.6 тэрбум төгрөгийн орлого олж, 150.4 тэрбум төгрөгийн зардал гаргаж 100.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зураг 4 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 36.2% буюу 66.6 тэрбум төгрөгөөр, зардлын хэмжээ 36.2% буюу 40.0 тэрбум төгрөгөөр, ашгийн хэмжээ 36.3% буюу 26.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 27 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/

ОРЛОГО	2018-III	2019-III	Нийт дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Хүүгийн орлого	155,501.7	210,005.4	83.8%	54,503.6	35.1%
Хүүгийн бус орлого	22,395.3	35,977.1	14.4%	13,581.8	60.6%
-Санхүүгийн үйлчилгээний орлого	14,086.1	28,819.3	11.5%	14,733.2	104.6%
- Итгэлцлийн үйлчилгээний орлого	2.8	1.6	0.0%	(1.2)	-42.1%
- Мөнгөн гуйвуулгын орлого	1,001.4	710.7	2.5%	(290.6)	-29.0%
- Картын үйлчилгээний орлого	-	841.9	2.9%	841.9	0.0%
- Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	117.3	217.8	0.8%	100.5	85.7%
- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	9,021.4	21,383.7	74.2%	12,362.3	137.0%
- Бусад	3,943.2	5,663.5	19.7%	1,720.2	43.6%
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6,024.5	4,584.8	1.8%	(1,439.7)	-23.9%
НИЙТ ОРЛОГО	183,921.5	250,567.3	100.0%	66,645.8	36.2%
ЗАРДАЛ					
Хүүгийн зардал	14,414.4	25,745.5	17.1%	11,331.1	78.6%
Хүүгийн бус зардал	67,071.1	81,667.1	54.3%	14,596.0	21.8%
Болзошгүй эрсдэлийн зардал	17,787.3	27,156.1	18.1%	9,368.8	52.7%
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2,271.3	2,124.0	1.4%	(147.3)	-6.5%
Орлогын албан татварын зардал	8,879.8	13,712.3	9.1%	4,832.5	54.4%
НИЙТ ЗАРЛАГА	110,423.9	150,405.0	100.0%	39,981.1	36.2%
АШИГ					
ЦЭВЭР ОРЛОГО	73,497.6	100,162.3	100.0%	26,664.7	36.3%

Өмнөх оны мөн үеэс хамгийн их өөрчлөлт орсон үзүүлэлтийг харвал орлогын хувьд хүүгийн бус орлого 60.6% буюу 14.7 тэрбум төгрөгөөр өссөн ба энэ нь үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого 2.1 дахин өссөнтэй холбоотой. Финтек буюу санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн,

шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээ үзүүлэгч ББСБ-ууд зээлдэгчдийн хэрэглээнд зориулсан бичил зээл олгохдоо ихэвчлэн хүү тогтоохгүйгээр, шимтгэл авч байгаа нь энэхүү орлогыг нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн байна. Нийт үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлогын 79.0% буюу 16.9 тэрбум төгрөгийг финтек үйлчилгээ үзүүлж буй ББСБ-уудын орлого бүрдүүлж байна.

Зардлын хувьд өмнөх оны мөн үеэс хамгийн их өсөлт үзүүлсэн нь хүүгийн зардал байна. Хүүгийн зардал нь 78.6% буюу 11.3 тэрбум төгрөгөөр өсжээ.

Нийт зардлын өсөлтийн 36.5 хувийг хүүгийн бус зардлын өсөлт бүрдүүлж байна. Хүүгийн бус зардал нь өмнөх оны мөн үеэс 21.8% буюу 14.6 тэрбум төгрөгөөр өсөж 81.7 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зардлын 54.3 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 28 Орлого, үр дүнгийн тайлан /тэрбум төгрөгөөр/

ОРЛОГО	Нийт	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО	Дотоод
Хүүгийн орлого	210.0	189.6	20.4	0.01	204.3	5.7	16.4	193.6	35.5	174.5
Хүүгийн бус орлого	36.0	16.9	18.2	0.90	35.6	0.4	15.3	20.7	4.0	32.0
- Санхүүгийн үйлчилгээний орлого	28.8	11.2	17.5	0.07	28.5	0.4	14.7	14.1	3.0	25.9
Итгэлцлийн үйлчилгээний орлого	0.0016	0.0016	-	-	0.0016	-	-	0.0016	-	0.0016
Мөнгөн гуйвуулгын орлого	0.7	0.7	-	-	0.7	-	-	0.7	0.014	0.7
Картын үйлчилгээний орлого	0.8	0.8	-	-	0.8	-	-	0.8	-	0.8
Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	0.2	0.2	-	-	0.2	-	-	0.2	-	0.2
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	21.4	4.4	16.9	0.07	21.1	0.3	14.1	7.3	1.0	20.3
Бусад	5.7	5.0	0.6	0.0003	5.6	0.1	0.6	5.0	1.9	3.7
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	4.6	4.1	0.5	0.0032	4.4	0.2	0.4	4.1	0.9	3.6
НИЙТ ОРЛОГО	250.6	210.7	39.0	0.91	244.3	6.3	32.2	218.4	40.5	210.1
ЗАРДАЛ										
Хүүгийн зардал	25.7	20.9	4.9	-	25.6	0.1	4.2	21.5	5.3	20.4
Хүүгийн бус зардал	81.7	67.2	13.6	0.90	79.5	2.1	10.6	71.0	13.7	68.0
Болзошгүй эрсдэлийн зардал	27.2	22.8	4.3	-	26.6	0.6	3.2	24.0	3.8	23.3
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	2.1	1.9	0.2	0.0023	2.1	0.1	0.2	2.0	0.3	1.9
Орлогын албан татварын зардал	13.7	11.1	2.6	0.02	13.4	0.3	2.4	11.3	2.7	11.0
НИЙТ ЗАРЛАГА	150.4	123.9	25.6	0.92	147.2	3.2	20.6	129.9	25.8	124.6
АШИГ										
ЦЭВЭР ОРЛОГО	100.2	86.8	13.4	(0.01)	97.1	3.1	11.6	88.6	14.7	85.5

Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын 10.5 сая төгрөгийн хүүгийн орлогыг 1 ББСБ-ын банкин дахь харилцах дансны хүүгийн орлого бүрдүүлж байна.

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

2019 оны III улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн дүнгээр 539 ББСБ-ын 92.8% буюу 500 ББСБ үйл ажиллагааны ЗХШҮ-үүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Нийт ББСБ-уудын 7.2% нь буюу 39 ББСБ-ын зохистой харьцаа алдагдсан байна. Үүнд: 1 зохистой харьцааг хангаагүй 35 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 3 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 1 ББСБ байна.

Хүснэгт 29 ЗХШҮ хангаагүй ББСБ-ын тоо

№	ЗХШҮ-ийн хэрэгжилт	Итгэлцэл		Зээл		ЗГВА		Нийт		539
		√	X	√	X	√	X	√	X	
	ББСБ-ЫН ТОО	27	4	429	34	44	1	500	39	
1.	1 ЗХШҮ	28	3	432	31	44	1	504	35	
2.	2 ЗХШҮ	30	1	461	2	45	-	536	3	
3.	3 ЗХШҮ	31	-	462	1	45	-	538	1	

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг Хорооны 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 210 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Үүний дагуу ББСБ-уудын ЗХШҮ-ийг үйл ажиллагааны төрлөөс хамааруулан өөрөөр тогтоосон байсныг нэг болгосон бөгөөд ингэхдээ гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг болон итгэлцлийн үйл ажиллагаанаас бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-уудад холбогдох харьцаа үзүүлэлт хамаарахгүй байхаар тусгасан.

Хүснэгт 30 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/

№	Эрхлэх үйл ажиллагааны төрөл	Хангах шаардлагатай ББСБ-ын тоо	Итгэлцэл	31	Итгэлцэлээс бусад	463	ЗГВА	45	Нийт	539
	Хангасан	Хангаагүй	√	X	√	X	√	X	√	X
Хангах шаардлагатай ЗХШҮ-ийн тоо		Хангаагүй ЗХШҮ-ийн тоо	18	4	17	10	6	1	18	11
1.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа		31	-	462	1	45	-	538	1
2.	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа		31	-	462	1	45	-	538	1
3.	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа		31	-	462	1	45	-	538	1
4.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа		31	-	463	-	45	-	539	
5.	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу)		31	-	463	-		-	539	-
6.	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа		31	-	453	10		-	529	10
7.	ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа		31	-	462	1		-	538	1
8.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дунгийн зохистой харьцаа		30	1	461	2		-	536	3
9.	ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа		30	1	459	4	XXXXX	-	534	5
10.	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа		31	-	463	-		-	539	-
11.	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа		31	-	463	-		-	539	-
12.	Монголын хөрөнгийн биржийн "I", "II" ангилалын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа		31	-	463	-		-	539	-
13.	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа		31	-	463	-		-	539	-
14.	Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа		31	-	462	1		-	538	1
15.	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа		31	-	457	6		-	533	6
16.	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа		30	1	XXXXX			-	538	1
17.	Өрийн бичгийн зохистой харьцаа		31	-	463	-	45	-	539	-
18.	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа		29	2	452	11	44	1	525	14

ББСБ-уудын хангах ёстой ЗХШҮ-үүдээс үндсэн хөрөнгийн зохистой харьцааг 14 ББСБ, нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцааг 10 ББСБ, гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцааг 6 ББСБ, ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцааг 5 ББСБ тус тус хангаж ажиллаагүй буюу хамгийн ихээр алдагдсан байна.

Дүгнэлт

2019 оны III улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 539 ББСБ-аас 96.5% буюу 520 ББСБ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 19 ББСБ эхлэлтийн болон өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

2019 оны III улирлын байдлаар давхардсан тоогоор 7,672 хувь нийлүүлэгчдийн 539 ББСБ, 240 салбар нэгж, 7 төлөөлөгчийн газар, 3003 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт 1,575,389 харилцагч, 383,670 зээлдэгчид хүрч үйлчилж байна. ББСБ-уудыг төвлөрлөөр авч үзвэл 465 ББСБ, 74 салбар Улаанбаатар хотод, 74 ББСБ, 166 салбар хөдөө орон нутагт бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2019 оны III улиралд ББСБ-уудын актив 1.6 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 35.5% буюу 426.5 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 26.7% буюу 343.6 тэрбум төгрөгөөр өсөж банкны салбарын нийт активын 4.7 хувьтай тэнцэж байна.

Нэгтгэлийн дүнгээр активын төвлөрлийг авч үзвэл 2.5 тэрбум хүртэл хөрөнгөтэй 406 ББСБ нийт активын 31.8 хувийг, 2.5 тэрбум ба түүнээс дээш хөрөнгөтэй 133 ББСБ нийт активын 68.2 хувийг бүрдүүлж байна.

Салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 1.2 их наяд төгрөгт хүрсэн нь банкны салбарын зээлийн өрийн үлдэгдлийн 6.5 хувьтай тэнцэж байгаа бөгөөд үүний 1,015.8 тэрбум төгрөг буюу 86.9 хувийг хэвийн зээл, 48.8 тэрбум төгрөг буюу 4.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 104.7 тэрбум төгрөг буюу 9.0 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байгаа ба хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 153.7 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 51.0%-д буюу 78.3 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулсан байна.

Нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 0.2 болон 1.6 пунктээр тус тус буурсан бол хэвийн зээлийн хэмжээ 1.8 пунктээр өссөн байна.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 494 ББСБ-аас 437 ББСБ нийт 1.3 их наяд төгрөгийн зээлийг 3.1 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгосон нь банкны салбартай харьцуулахад 1.7 пунктээр өндөр байна.

ББСБ-уудын пассивын бүтцийг харвал 26.2% буюу 425.9 тэрбум төгрөгийг бусдаас татсан эх үүсвэр, 73.8% буюу 1.2 их наяд төгрөгийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байна. 2019 оны III улирлын байдлаар 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 100 ББСБ байгаа ба салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 44.2 хувийг эзэлж байна. Нийт банк бус санхүүгийн байгууллагуудыг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр бүлэглэхэд 1.4-2.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 290 ББСБ 48.5 хувийг эзэлж байгаа бол 1.4 тэрбумаас доош хөрөнгөтэй 149 ББСБ 7.3 хувийг бүрдүүлж байна.

2019 оны III улирлын байдлаар ББСБ-ууд 250.6 тэрбум төгрөгийн орлого олж, 150.4 тэрбум төгрөгийн зардал гаргаж 100.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт ББСБ-ын 92.8% буюу 500 ББСБ зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан бол үлдэх 39 ББСБ буюу 7.2% нь зохистой харьцааны зарим үзүүлэлтийг хангаагүй байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР